

Албан ёсны чөлөөний журмын талаар

2025 оны 4 сарын 1 -ээс хэрэгжих

Албан ёсны чөлөөнд (тасалсанд тооцогдохгүй чөлөө) хамаарах зүйлс:

- ① Шалгалт ...элсэлтийн шалгалт, ажлын ярилцлага, суралцахаар төлөвлөж буй сургуулийн элсэлтийн өмнөх танилцуулга гэх мэт.
※Хэрэв шалгалт өгөх сургууль хол бол шалгалтын өмнөх болон дараах нэг өдрийг ирэх очих өдөр гэж тооцож, албан ёсоор чөлөө олгоно.
Хол гэдэг нь "Токио, Канагава, Чиба, Сайтама мужуудаас гадна" бүс нутгууд болно.
- ② Халдварт өвчин ...Коронагийн халдвар, томуу, сүрьеэ гэх мэт хуулиар заасан халдварт өвчин
Жишээ нь: Коронагийн тохиолдолд PCR шинжилгээ өгснөөр хариу эерэг гарсан бол өвчин эхэлсэн үеэс (шинж тэмдэг илэрсэн үеэс) таван хоногийн хугацаанд албан ёсоор чөлөө олгогдоно.
- ③ Бусад ...Элчин сайдын яаманд очих шаардлагатай үед (зөвхөн заасан цагтай бол)
Галт тэрэг зогссон үед
Гашуудлын чөлөө (өвөө эмээ, эцэг эх, ах дүү нас барсан тохиолдолд таван өдөр хүртэл албан ёсны чөлөө олгоно)
★Хуримын ёслол (ах дүү, хүү, охин гэрлэх гэж байгаа тохиолдолд гурван өдөр хүртэл албан ёсны чөлөө олгоно)
★Өөрийн төгсөлтийн шалгалт өөрийн улсад болох тохиолдолд таван өдөр хүртэл албан ёсны чөлөө олгоно

Бусад, хулгайд өртөх, зам тээврийн осол, гамшиг гэх мэт сургуулийн захирлын зөвшөөрсөн онцгой нөхцөл

※① нь зөвхөн тодорхой өдөр, цаг заасан зайлшгүй оролцох шаардлагатай зүйлд хамаарна. Өөрийн боломжтой цагийг зааж болох эсвэл заавал оролцохгүйгээр шалгалт өгөх боломжтой арга хэмжээ нь албан ёсны чөлөөнд хамрахгүй.

※② -т ойрын хавьтагч хамаарахгүй тул албан ёсны чөлөөнд хамрагдахгүй. Маск зүүн хичээлд оролцох шаардлагатай.

※② -ийн хувьд хэрэв эмчилгээний хугацаа дууссаны дараа шинж тэмдэг арилахгүй бол сургуультай зөвлөлдөнө үү!

Хэрэв халуурахаас бусад шинж тэмдгийн улмаас (хоолой өвдөх, ханиалгах гэх мэт) ирээгүй бол хичээл тасалсанд тооцох боловч өөр халдварт өвчин туссан байх эрсдэлтэй тул яаралтай эмнэлэгт хандана уу!

※① Шалгалт ③ дахь ★-тай холбоотой тохиолдолд албан ёсны чөлөө авах өдрөөс 1 долоо хоногийн өмнө урьдчилан мэдүүлнэ үү.

Бусад тохиолдолд сургуульдаа дахин ирж чадах болсноос хойш 1 долоо хоногийн дотор яаралтай мэдүүлнэ үү!

Албан ёсны чөлөө авах хүсэлт гаргах арга

Сургуулийн хүлээн авахд очиж, шалтгаанаас хамааран урьдчилан эсвэл дараа нь албан ёсны чөлөөний маягтад шаардлагатай мэдээллийг бөглөж, доор дурдсан хавсралт бичиг баримтын хамт хүлээн авахд өгнө үү.

① Шалгалт... Шалгалтын хуудас эсвэл ярилцлагын талаархи мэдэгдэл имэйл заавал шаардлагатай. Мөн шалгалтын 「Өдөр болон газар」 нь тодорхой харагдах баримт (хэрэв шалгалтын хуудсанд бичигдээгүй бол сургуулийн танилцуулгын холбогдох хуудасны зураг гэх мэт) -ийг бүгдийг нь 1 зураг болгох.

② Коронагийн халдвар ... PCR шинжилгээний эерэг гарсан нь харагдах баримт

Томуу, сүрьеэ зэрэг хуулиар тогтоосон халдварт өвчин ... Оношийн бичиг гэх мэт

③ Бусад

Элчин сайдын яаманд заавал очих шаардлагатай үед (цаг заасан тохиолдолд л) ... Бүртгэлийн хуудас, имэйл зэрэг

Галт тэрэг зогссон үед ... Галт тэрэг саатсан тодорхойлолт

Гашуудал (өвөө, эмээ, эцэг эх, ах, эгч, дүү нас барсан үед) ... Нас барсны тодорхойлолт гэх мэт

Хурим (ах, эгч, дүү, хүү, охины хурим болсон үед) ... Хуримын урилга гэх мэт